



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

“Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө, 2026-2027 оны төсвийн төсөөлөл”-ийг батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г энэхүү тогтоолын Нэгдүгээр, “ХХЗХ-ны 2025 оны орлогын төлөвлөгөө”-г Хоёрдугаар, “ХХЗХ-ны 2025 оны зардлын төлөвлөгөө”-г Гуравдугаар, “ХХЗХ-ны 2025 оны хөрөнгө оруулалтын зардал”-ыг Дөрөвдүгээр, “ХХЗХ-ны 2025 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ыг Тавдугаар, “ХХЗХ-ны 2025 оны үйл ажиллагааны зардал”-ыг Зургаадугаар, “ХХЗХ-ны 2026-2027 оны төсвийн төсөөлөл”-ийг Долоодугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар баталсан Хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, батлагдсан зардал, төсвийг зориулалтын дагуу зарцуулан тухай бүр гүйцэтгэлийг тайлагнан ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИЦЛҮҮД

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 251 тоот тогтоолын Нэгдүгээр хавсралт

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
НЭГ. БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ЗОРИЛТУУДЫГ ХАНГАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ							
ДД	Стратегийн зорилго, зорилт	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
1.1. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙ ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ, ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛНЭ.							
1	Сүлжээний бүсчилсэн топологи, сүлжээний үйлчилгээний газарзүйн ялгаваргүй тарифын зохицуулалт хэрэгжүүлэх	1-1-1.1	2024 онд гүйцэтгэсэн судалгааны саналд үндэслэж харилцаа холбооны сүлжээний зохицуулалтын холбогдох баримт бичгүүдэд нөлөөллийн шинжилгээ хийх	ЗГ	ЗЗҮТЗГ	1-2-р улирал	Холбогдох зохицуулалтын баримт бичгүүдэд нөлөөллийн шинжилгээ хийж, санал дүгнэлтийг ДЗХ-д танилцуулсан байна.
2		1-1-1.2	Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх болон интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийн зохицуулалтын агуулгад өөрчлөлт оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэх	ЗЗҮТЗГ	ЗГ	2-3-р улирал	Холбогдох тусгай зөвшөөрлийн зохицуулалтуудад өөрчлөлт оруулах санал боловсруулж, сүлжээ бүхий үйлчилгээ эрхлэгчдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан, ДЗХ-д танилцуулсан байна.
3	Нээлттэй сүлжээний зарчим, дэд бүтэц хамтран ашиглах зохицуулалт хэрэгжүүлэх	1-1-2.1	Харилцаа холбооны сүлжээний зохицуулалтын чиглэлээр авах арга хэмжээг хүчин төгөлдөр мөрдөж буй хууль эрх зүйд нийцүүлэх талаар судалгаа хийх	ЗГ		1-2-р улирал	Судалгааны тайлан хүлээн авч, дүгнэлтийг хэлэлцүүлсэн байна.
4		1-1-2.2	Харилцаа холбооны сүлжээ, идэвхгүй дэд бүтэц хамтран ашиглах зохицуулалтын санал боловсруулах	ЗГ		2-р улирал	Харилцаа холбооны сүлжээ, идэвхгүй дэд бүтэц хамтран ашиглах зохицуулалтын саналыг ДЗХ-д танилцуулсан байна.
5	Шуудангийн харилцан холболтыг нэмэгдүүлэх, бүсчилсэн тогтолцоо нэвтрүүлэх	1-1-3.1	Шуудангийн харилцан холболтын чиг хандлага, олон улсын нөхцөл байдлыг судалж, зохицуулалтын санал боловсруулах	ЗЗҮТЗГ	ШЗГ	2-3-р улирал	Олон улсын туршлага, судалгаанд үндэслэж, шуудангийн харилцан холболтын журамд өөрчлөлт оруулах, орчин үеийн чиг хандлагад суурилсан холболтын зарчим боловсруулж ДЗХ-д танилцуулсан байна.
6		1-1-3.2	Цахим худалдаа эрхлэгч болон шуудангийн хүргэлтийн үйлчилгээ эрхлэгч хоорондын хамтын ажиллагааг дэмжих	ШЗГ	ЗГ	2-р улирал	Шуудангийн үйлчилгээ эрхлэгч, хүргэлтийн үйлчилгээ эрхлэгчид болон цахим худалдаа эрхлэгчдийг хамруулсан уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.
1.2. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРТ ӨРСӨЛДӨӨН, ИННОВАЦИЙГ ДЭМЖИН, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖИХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ.							

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



А.ЛУВСАН-ОЧИР

Хуудас 1 нийт 43

ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
7	Дараа үеийн холболт, харилцан холболтын зохицуулалт, нээлттэй сүлжээний зарчмыг нэвтрүүлэх	1-2-1.1	Харилцаа холбооны сүлжээ хоорондын харилцан холболт, сүлжээнд холбогдох зохицуулалтын олон улсын чиг хандлага, дотоодын нөхцөл байдлын талаар судалгаа хийж, зохицуулалтын санал боловсруулах	ЗГ	ЗЗҮТЗГ	Жилдээ	Харилцан холболт, сүлжээнд холбогдох зохицуулалтын олон улсын чиг хандлага болон 5G, Мобайл виртуал сүлжээ, Мобайл хувийн сүлжээний (MPN, MVPN, MVNх концепц) талаар судалгаа хийж, зохицуулалтын саналыг ДЗХ-д тус тус танилцуулсан байна.
8		1-2-1.2	Харилцаа холбооны тусгай зөвшөөрлийн зарчмын (licensing framework) олон улсын чиг хандлагын талаар судалгаа хийх, зохицуулалтын санал боловсруулах	ЗГ	ЗЗҮТЗГ ЗУХАГ	3-4-р улирал	Тусгай зөвшөөрлийн зарчмын судалгааг хийж, зохицуулалтын саналыг ДЗХ-д танилцуулсан байна.
9		1-2-1.3	ОСДҮ, ТВ хоорондын холболтын асуудлыг зохицуулж буй эрх зүйн баримт бичгүүдэд (ӨНТХ, Харилцан холболтын журам, Үндсэн багцын журам, нөхцөл шаардлага зэрэг) нөлөөллийн шинжилгээ хийж, өөрчлөлт оруулах санал боловсруулах	ЗЗҮТЗГ	ӨНЗГ	1-2-р улирал	2024 онд ОСДҮ, ТВ хоорондын холболтын талаар хийсэн судалгааны үр дүнд үндэслэж, холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд өөрчлөлт оруулах төсөл боловсруулж танилцуулсан байна.
10	Хязгаарлагдмал нөөц (Радио давтамж, Дугаарлалт) -ийг үр ашигтай удирдаж, шинэ технологи, инновацийн хэрэгцээ, ил тод байдлыг хангах	1-2-2.1	Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох журамд өөрчлөлт оруулах санал боловсруулах	ЗЗҮТЗГ	РДЗХГ	1-2-р улирал	Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох журманд өөрчлөлт оруулах санал боловсруулан ДЗХ-д танилцуулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.
11		1-2-2.2	Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох	РДЗХГ	Ажлын хэсэг ХХНБД	Жилдээ	Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд (5G) радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үр дүнг Хорооны хуралдаанд танилцуулсан байна.
12		1-2-2.3	Мэдээлэл харилцаа холбооны салбар болон бусад салбартай хамтарсан "Инновац-технологи"-ийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	ЗГ			2, 4-р улирал
13		1-2-3.1	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшлийн мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх	ӨНЗГ		1-р улирал	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн талаарх шинэчилсэн мэдээллийг Хорооны цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн байна.

ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
14	Өргөн нэвтрүүлгийн хараат бус нээлттэй байдлыг хангах, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх зохицуулалт хэрэгжүүлэх	1-2-3.2	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх	ӨНЗГ	ЗЗҮТЗГ	1-2-р улирал	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөл байдалд үнэлгээ дүгнэлт хийж танилцуулсан, байгууллагын цахим хуудсанд нээлттэй мэдээлсэн байна.
15		1-2-3.3	Зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл байдлыг үнэлэх, нээлттэй байдлыг хангах зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн өөрчлөлтийн мэдээллийг гаргаж, олон нийтэд мэдээлэх	ӨНЗГ		Улирал бүр	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний тоон мэдээг улирал тутам гаргаж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.
16		1-2-3.4	2025 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох	ӨНЗГ	ЗЗҮТЗГ	2-р улирал	2025 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн төрөл, тоог аргачлалын дагуу тодорхойлсон, үнэлэлт, дүгнэлт гаргасан, Хорооны хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлсэн байна.
17		1-2-3.5	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн зохиогчийн эрхтэй бүтээлийн www.copyright.crc.gov.mn нээлттэй системийн ашиглалт, хэрэглээний байдалд үнэлгээ хийх	ӨНЗГ		1, 3-р улирал	www.copyright.crc.gov.mn системийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт, дүгнэлт гаргаж, холбогдох талуудтай (ОӨГ, МОӨХХ, мэргэжлийн холбоод) уулзалт зохион байгуулсан, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулсан, дүгнэлт, зөвлөмж, тайланг Хорооны цахим хуудсанд байршуулсан байна.
18		1-2-4.1	Шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд ногоон шуудангийн чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгөх	ШЗГ		3-4-р улирал	Ногоон шуудангийн чиглэлээр гарын авлага, зөвлөмж боловсруулж, шуудангийн үйлчилгээ эрхлэгчдэд түгээсэн байна.
19	Шуудангийн зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх	1-2-4.2	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааны цахим нэвтрэлтийн байдалд үнэлгээ өгөх	ШЗГ	ЗГ	1-р улирал	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааны цахим нэвтрэлтийн байдалд үнэлгээ хийх аргачлал боловсруулсан, аргачлалын дагуу үйлчилгээ эрхлэгчид үнэлгээ өгч, үр дүнг ДЗХ-д танилцуулсан байна.
20		1-2-4.3	Шуудангийн ухаалаг хайрцагны хэрэглээ, хүртээмж, шуудангийн хүргэлтийн техник хэрэгслийн судалгаа хийх	ШЗГ		1-3-р улирал	Монгол улсын шуудангийн үйлчилгээнд ухаалаг хайрцаг, цахилгаан тээврийн хэрэгслийн нэвтрэлтийн судалгааг хийж, танилцуулсан, үр дүнг холбогдох зөвлөмж, танилцуулгад ашигласан байна.



ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
21	Хэрэглэгчийн сүлжээ, төгсгөлийн төхөөрөмжийн нэгдсэн стандарт хэрэгжүүлэх замаар хэрэглэгчийн сонголтыг чөлөөтэй болгох	1-2-5.1	Харилцаа холбооны үйлчилгээний талаар хэрэглэгчид өгөх зөвлөмж, заавар боловсруулж, хэрэглэгчийг мэдээллээр хангах	ЗУХАГ	Бүх газар	Жилдээ	Харилцаа холбооны үйлчилгээний талаар хэрэглэгчид өгөх зөвлөмж, заавар боловсруулж байгууллагын цахим хуудсын "хэрэглэгч" цэсэнд байршуулсан, хэрэглэгчид мэдээлсэн байна.
1.3. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3. ХАРИЛЦАА ХОЛБОО, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАРТАЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛНЭ.							
22	Харилцаа холбооны үйлчилгээний чанарын хяналтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх	1-3-1.1	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс статистик тайлангийн хүрээнд ирүүлсэн үйлчилгээний чанарын тайлан, мэдээг нэгтгэн боловсруулж үнэлгээ, дүгнэлт өгөх	ЗГ	ЗЗҮТЗГ	2-р улирал	Харилцаа холбооны үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2024 оны жилийн эцсийн тайланд ирүүлсэн үйлчилгээний чанарын тайлан мэдээг нэгтгэн боловсруулж, үнэлгээ дүгнэлт гаргаж, танилцуулсан, нээлттэй мэдээлсэн байна.
23		1-3-1.2	Интернетийн чанарын хэмжилтийн системийн ашиглалт үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах	ЗГ		Жилдээ	Интернетийн чанарын хэмжилт хийх speedtest.mn системийн ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулан, хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.
24		1-3-1.3	Интернетийн чанарын хэмжилтийг олон улсын серверт хийх	ЗГ		Жилдээ	Интернетийн чанарын хэмжилтийг гадаадын сервер рүү хийж, үр дүнг танилцуулсан байна.
25		1-3-1.4	Шуудангийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчилгээний чанарыг хянах зорилгоор шуудангаар үйлчлүүлэгчдээс цахимаар (QR код ашиглан) судалгаа авах	ШЗГ		Жилдээ	Шуудангаар үйлчлүүлэгчдээс цахим системээр судалгаа авч, тайланг танилцуулсан байна.
26		1-3-1.5	Дууны чанга дуугаралтын түвшингийн талаарх норматив/зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах	ӨНЗГ		Улирал бүр	Телевизүүдийн дууны түвшинд хэмжилт хийж тайлан гаргасан, телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд норматив/зөвлөмжийг хэрэгжүүлэх зөвлөмж өгч, сургалт зохион байгуулсан байна.
27		1-3-1.6	Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн студийн техник, технологийн өнөөгийн нөхцөлд байдалд судалгаа хийх	ӨНЗГ		2-4-р улирал	Телевизийн үйлчилгээ эрхлэгчийн студийн техник, технологийн өнөөгийн нөхцөл байдлын талаар судалгаа хийж танилцуулсан байна.
28		1-3-1.7	Олон суваг дамжуулах сүлжээний телевизээс дохио хүлээн авах, хэрэглэгчид хүргэх зурвасын багтаамж, дамжуулах хурд, сүлжээний төлөвлөлтийн байдалд үнэлэлт, дүгнэлт гаргах	ӨНЗГ		1-2-р улирал	Олон суваг дамжуулах сүлжээний телевизээс дохио хүлээн авах, хэрэглэгчид хүргэх зурвасын багтаамж, дамжуулах хурд, сүлжээний төлөвлөлтийн өнөөгийн байдлын талаар судалсан, үнэлэлт, дүгнэлт гаргасан байна.
29		1-3-1.8	Үүрэн холбооны сүлжээний чанарын хэмжилт хийх	РДЗХГ		2, 4-р улирал	Үүрэн холбооны үйлчилгээний чанар, хамрах хүрээний хэмжилтийг хийж, үр дүнг ДЗХД танилцуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



А.ЛУВСАН-ОЧИР

Хуудас 4 нийт 43

ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
30		1-3-1.9	Харилцаа холбооны үйлчилгээний чанарын шаардлагын талаар судалгаа хийх, зохицуулалтын санал боловсруулах	ЗГ	РДЗХГ	3-4-р улирал	Харилцаа холбооны үйлчилгээний чанарын шаардлагыг тодорхойлж, баримт бичгээр баталгаажуулах (үйлчилгээ эрхлэгчид үүрэг хүлээлгэх, нөхцөл шаардлагад тусгах) талаар зохицуулалтын санал боловсруулж, ДЗХ-д танилцуулсан байна.
31		1-3-1.10	Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үүрэн холбооны сүлжээний хамрах хүрээг тооцоолох, ил тод мэдээлэх	РДЗХГ		2, 4-р улирал	Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдээс хагас жил, жилийн эцсийн тайлангийн хүрээнд ирүүлсэн 2G, 3G, 4G, 5G технологийн бааз станцуудын байршлын мэдээлэлд үндэслэн coverage.cgc.gov.mn сайтад үүрэн холбооны хамрах хүрээний мэдээллийг байршуулсан байна.
32	Үндэсний радио долгионы хяналтын үйл ажиллагааг сайжруулах, бүсчилсэн тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх	1-3-2.1	Үндэсний радио долгионы хяналтын үйл ажиллагаанд "MNS ISO/IEC 17020:2013 – тохирлын үнэлгээ, хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага" стандартын хэрэгжилтийг ханган ажиллах	РДЗХГ		Жилдээ	Хяналтын төвийн үйл ажиллагаа нь MNS ISO/IEC 17020:2013 стандартын шаардлагуудыг хангаж байгааг нотолж, үйл ажиллагааг Үндэсний итгэмжлэлийн төвөөр итгэмжлүүлсэн гэрчилгээг авсан байна.
33		1-3-2.2	Үндэсний радио долгионы удирдлага, хяналтын нэгдсэн тогтолцоо нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлэх	РДЗХГ		Жилдээ	Төслийн хүрээнд радио долгионы бүсийн төв байгуулахад шаардлагатай дэд бүтэц, тоног төхөөрөмжийн шаардлага, үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлсон, гүйцэтгэгч байгууллагын гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.
34		1-3-2.3	Үндэсний радио долгион хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд шаардагдах суурин хяналтын станцыг байршуулах газрын судалгааг хийх	РДЗХГ		Жилдээ	Бүсийн төв, суурин хяналтын станц байршуулах газрын судалгааг хийж, газрыг эцэслэн тодорхойлсон байна.
35	Харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын тогтолцоонд лабораторийн баталгаажуулалт нэвтрүүлэх	1-3-3.1	Харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын лаборатор байгуулах	РДЗХГ	ЗУХАГ	Жилдээ	Төслийн хүрээнд баталгаажуулалтын лаборатор байгуулахад шаардлагатай барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн шаардлага, үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлсон, гүйцэтгэгч байгууллагын гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.
36		1-3-3.2	Олон Улсын баталгаажуулалтын лаборатор (EMC, RF)-той хамтран ажиллах, хүний нөөцийг чадавхжуулах	РДЗХГ		Жилдээ	Олон Улсын баталгаажуулалтын лаборатортой (RAPA, RRA) хамтран ажиллах санамж бичгийн (MoU) хүрээнд хамтран ажилласан байна.

ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
37	Шуудангийн нэгдсэн кодыг хэрэглээнд төлөвшүүлэх	1-3-4.1	Шуудангийн нэгдсэн код шинэчлэн батлагдсантай холбогдуулан сургалт зохион байгуулах	ШЗГ		2-р улирал	Шуудангийн нэгдсэн кодын хэрэглээний талаар сургалтыг Улаанбаатар хотын 9 дүүрэгт, дүүргийн холбогдох ажилтнуудыг хамруулж зохион байгуулсан байна.
38		1-3-4.2		ШЗГ		2-р улирал	Шуудангийн нэгдсэн кодын талаарх видео контент бэлтгэн, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сошиал сувгуудаар мэдээлсэн байна.
39		1-3-4.3	Дэлхийн шуудан холбооны "Олон улсын өсвөр насны хүүхдүүдийн захидал бичих уралдаан"-ыг орон даяар зохион байгуулах	ШЗГ		1-2-р улирал	Уралдааныг зохион байгуулахдаа шуудангийн код, хаягийн бичвэрийн стандартыг шалгуур үзүүлэлтэд оруулж, уралдааны зард тодорхой тусгасан байна. Захидлын уралдааны үндэсний ялагчийн захидлыг олон улсын захидлын уралдаанд илгээсэн байна.
40	Өргөн нэвтрүүлгийн орчинд үндэсний дархлааг хамгаалах, олон нийтийн нийтлэг эрх ашиг, үзэгч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах	1-3-5.1	Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр олон нийтийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх	ӨНЗГ		Жилдээ	Өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах, гомдол хүлээн авах чиглэлээр баннер, нийтлэл/ярилцлага бэлтгэж Хорооны сэтгүүл, цахим хуудас, бусад мэдээллийн сайтад нийтлүүлсэн, олон нийтэд таниулсан байна.
41		1-3-5.2	Үндэсний бүтээл үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	ӨНЗГ		1-р улирал	2024 онд радио, телевизээр нэвтрүүлсэн үндэсний түүх, соёл уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн бүтээл үйлдвэрлэл, дохионы хэл, бичгэн тайлбартай нэвтрүүлэгт гарсан өөрчлөлтөд үнэлгээ дүгнэлт хийсэн байна.
42		1-3-5.3	Монгол Улсад үйлчилгээ эрхлэх хүрээтэй телевизүүдийн дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай телевизийн нэвтрүүлгийн хувь хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх	ӨНЗГ		1, 3-р улирал	Телевизүүдийн дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай нэвтрүүлгийн төлөвлөлт, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар дүгнэлт тайланг гаргаж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, танилцуулсан байна.
43		1-3-5.4	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр IPTV системийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал ITU-T H702.-ыг үе шаттай хэрэгжүүлэх	ӨНЗГ		2-р улирал	IPTV системийн суурь профайлыг хангахад шаардлагатай асуудлаар ОСДҮЭ-тэй хамтран ажилласан, зөвлөмж гарган хүргүүлсэн байна.
44		1-3-6.1	Цахим орчны зохицуулалтын чиг хандлагыг тодорхойлох, зохицуулалтын санал боловсруулах	ЗГ		2-4-р улирал	Цахим орчны зохицуулалтын чиглэлээр олон улсын туршлага, чиг хандлагыг судалж, зохицуулалтын саналыг ДЗХ-д танилцуулсан байна.

ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
45	Цахим орчинд хүүхдийн эрх, олон нийтийн нийтлэг эрх ашгийг хамгаалах	1-3-6.2	Цахим орчны контенттэй холбоотойгоор холбогдох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан шийдвэрийн дагуу хууль зөрчсөн вэб сайт, контентод технологийн арга хэмжээ авах	ЗГ		Тухай бүр	Эрх бүхий байгууллагуудаас ирсэн санал, дүгнэлт, шийдвэрийн дагуу зөрчилтэй вэбсайтыг "black-list.mn" системд бүртгэх, "Ногоон суваг" буюу "Content Reporting System (CRS)"-р хууль бус контентийг устгуулах хүсэлтийг хүргүүлэх зэрэг технологийн арга хэмжээ авсан байна.
46		1-3-6.3	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.6, 25.11, 25.12 дахь хэсгийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, цахим орчинд хүүхдийг хортой болон хориотой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэл түгээх	ЗГ		2-3-р улирал	Хэлэлцүүлэг арга хэмжээ зохион байгуулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, цахим орчинд хүүхдийг хортой болон хориотой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны талаар контент, мэдээлэл бэлтгэж, олон нийтэд түгээсэн байна.
47		1-3-6.4	Цахим орчны зохицуулалтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах	ЗГ		Жилдээ	Холбогдох байгууллагатай хамтран нөлөөллийн аян зохион байгуулж, заавар зөвлөмж гаргасан байна.
48		1-3-6.5	Цахим орчны зохистой хэрэглээ, олон нийтийн цахим аюулгүй байдлын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	ЗГ		Жилдээ	Олон нийтэд зориулсан сургалт, хэлэлцүүлэг, арга хэмжээ зохион байгуулсан байна.
49		1-3-6.6	Цахим орчны зохицуулалтын чиглэлээр холбогдох Олон улсын байгууллага, үндэстэн дамнасан платформуудтай хамтран ажиллах	ЗГ		Жилдээ	Үндэстэн дамнасан платформуудтай цахим орчны зохицуулалтын хүрээнд Монгол Улсын хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.
50		1-3-6.7	Цахим орчинтой холбоотой дүгнэлт, шийдвэрийг хэрэгжүүлэх report.crc.gov.mn/Black-list.mn системийн нэмэлт хөгжүүлэлт хийх	ЗГ		1-2-р улирал	Цахим орчны талаар гомдол хүлээн авах, шийдвэрлэх дотоод бүртгэлийн системд сайжруулалт хийж, тайлан мэдээллийг тодорхойлсон үзүүлэлтүүдийн дагуу хялбар энгийн гаргаж харуулдаг болгож ашиглалтад оруулсан байна.
51		1-3-6.8	Домэйн нэр, IP хаягийн бүртгэлийн pic.crc.gov.mn системийн нэмэлт хөгжүүлэлт хийх	ЗГ		1-2-р улирал	Холбогдох байгууллагаас домэйн нэрийн мэдээллийг шинэчлэн авдаг болох, АйПи хаягийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож сайжруулалт хийсэн байна.



ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
52		1-3-6.9	Цахим орчинд хүүхэд хамгааллын хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах	ЗГ		2-р улирал	Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах семинар, хэлэлцүүлгийг олон улсын болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна.
1.4. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4. ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИЛ ТОД, ШУУРХАЙ, ҮР АШИГТАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ							
53		1-4-1.1	"Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам"-д үнэлгээ хийх	ЗГ	ЗЗҮТЗГ	1-2-р улирал	"Зохицуулалтын баримт бичигт үнэлгээ хийх удирдамж"-ийн дагуу үнэлгээ хийсэн байна.
54		1-4-1.2	Харилцаа холбооны сүлжээ, хиймэл дагуулын сүлжээний зах зээл, зохицуулалтын үр нөлөөний байдалд судалгаа хийх	ЗЗҮТЗГ	ЗГ РДХЗГ	1-3-р улирал	Судалгааны үр дүнг ДЗХ-д танилцуулж нийтэд мэдээлсэн байна.
55		1-4-1.3	Харилцаа холбооны үйлчилгээ (яриа, интернэт, тусгай дугаар)-ний зах зээл, зохицуулалтын үр нөлөөний байдалд судалгаа хийх	ЗЗҮТЗГ	ЗГ РДХЗГ	1-3-р улирал	Судалгааны үр дүнг ДЗХ-д танилцуулж нийтэд мэдээлсэн байна.
56		1-4-1.4	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээл, зохицуулалтын үр нөлөөний байдалд судалгаа хийх	ЗЗҮТЗГ	ӨНЗГ РДХЗГ	1-3-р улирал	Судалгааны үр дүнг ДЗХ-д танилцуулж нийтэд мэдээлсэн байна.
57		1-4-1.5	Шуудангийн зах зээл, зохицуулалтын үр нөлөөний байдалд судалгаа хийх	ЗЗҮТЗГ	ШЗГ	1-3-р улирал	Судалгааны үр дүнг ДЗХ-д танилцуулж нийтэд мэдээлсэн байна.
58		1-4-1.6	Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлага (шуудангийн сүлжээ байгуулах), Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад үнэлгээ хийх	ШЗГ		1-2-р улирал	"Зохицуулалтын баримт бичигт үнэлгээ хийх удирдамж"-ийн дагуу үнэлгээ хийсэн байна.
59		1-4-1.7	Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, холбогдох баримт бичигт хууль зүйн шинжилгээ хийх, хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтын талаар санал боловсруулах	ӨНЗГ	ЗЗҮТЗГ ЗУХАГ	1-2-р улирал	Өргөн нэвтрүүлгийн эзэмшил, хэт төвлөрлийн зохицуулалт, үндсэн багцын зохицуулалт болон хөтөлбөр, зар сурталчилгааны шаардлагад хууль зүйн шинжилгээ судалгаа хийсэн, санал боловсруулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



А.ЛУВСАН-ОЧИР

Хуудас 8 нийт 43

ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
60	Зохицуулалтын үр нөлөө, үр ашигтай байдалд үнэлгээ хийх, тайлагнах нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх	1-4-1.8	Харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээний зохицуулалтын холбогдох баримт бичгүүдэд хууль зүйн шинжилгээ хийх, хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтын талаар санал боловсруулах	ЗГ	ЗЗҮТЗГ ЗУХАГ	1-2-р улирал	Харилцан холболт, дугаарлалт, сүлжээний зохицуулалтын холбогдох баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж танилцуулсан байна.
61		1-4-1.9	Шуудангийн зохицуулалтын холбогдох баримт бичгүүдэд хууль зүйн шинжилгээ хийх, хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтын талаар санал боловсруулах	ШЗГ	ЗЗҮТЗГ ЗУХАГ	1-2-р улирал	Шуудангийн харилцан холболтын журамд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж танилцуулсан байна.
62		1-4-1.10	Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын баримт бичигт хяналт шинжилгээ үнэлгээ хийх	ӨНЗГ		1-2-р улирал	Телевизийн хөтөлбөр, зар сурталчилгааны зохицуулалтын баримт бичиг, Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын баримт бичигт хяналт шинжилгээ үнэлгээг хийж, дүгнэлт санал гаргаж танилцуулсан байна.
63		1-4-1.11	Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах	ӨНЗГ		2-4-р улирал	Шаардлагатай баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, хэлэлцүүлсэн, Хорооны хуралдаанд танилцуулсан байна.
64		1-4-1.12	Радио, телевиз, цахим орчин ашиглан нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны талаар хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтын санал боловсруулах	ӨНЗГ	ЗГ	1-2-р улирал	Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай, Аймаг нийслэл сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал боловсруулж, хэлэлцүүлсэн, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.
65		1-4-1.13	Зохицуулалтын үйл ажиллагааны талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс сэтгэл ханамжийн судалгаа авах	ЗЗҮТЗГ	Бүх газар	1-2-р улирал	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс судалгаа авч, үр дүнг ДЗХ-д танилцуулсан байна.
66		1-4-1.14	Харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын үйл ажиллагаанд мөрдөж буй баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх	РДЗХГ		Жилдээ	Баталгаажуулалтын үйл ажиллагаанд мөрдөж буй 11 баримт бичигт дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт, саналыг ДЗХ-д танилцуулсан байна.

ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
67	Зохицуулалтын хэрэгжилт хангуулах тогтолцооны нотолгоонд суурилсан ил тод, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх	1-4-2.1	Тусгай зөвшөөрлийн бүртгэл, төлбөр тооцооллын програм (billing.crc.gov.mn)-д нэмэлт хөгжүүлэлт хийх	ЗУХАГ		Жилдээ	Тусгай зөвшөөрлийн бүртгэл, төлбөр тооцооллын програм (billing.crc.gov.mn)-д дараах нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна: * Зээлийн мэдээлийн санд мэдээлэл нийлүүлэх тухай баталгааны маягтыг үйлчилгээ эрхлэгчдээр зуруулах процессыг автоматжуулах; * Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээний нэмэлт, өөрчлөлтийг системд оруулах, үр дүнг нягтлах, тестлэх, засварлах, нэвтрүүлэх; * Зохицуулалтын хүрээнд хийгдэх бусад нэмэлт ажлууд;
68		1-4-2.2	Тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээ, эрхийн бичгийн хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор зөвшөөрлийн хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд цахимаар хүсэлт гаргах тухай зөвлөгөө, мэдээлэл өгөх	ЗУХАГ	Бүх газар	Жилдээ	2025 онд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах 173 үйлчилгээ эрхлэгчдэд сургалт зохион байгуулж, тусгай зөвшөөрлийн сунгалтын хүсэлтийн 50-иас доошгүй хувийг цахим хэлбэрээр хүлээн авсан байна. Зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар илгээх видео заавар бэлтгэж, мэдээлсэн байна.
69		1-4-2.3	Байгууллагын цахим хуудсанд нэмэлт, хөгжүүлэлт хийх	ЗУХАГ	Бүх газар	2-р улирал	Байгууллагын цахим хуудасны агуулга, удирдах хэсгийг сайжруулах, Монгол-Англи хувилбарыг ялгаатай хөтлөх боломжийг нэмэх, интерфэйсийн дизайныг шинэчлэх, гар утаснаас харагдах байдлыг сайжруулсан байна.
70		1-4-2.4	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2024 оны жилийн эцсийн статистик мэдээ, тайлан авч, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэх	ЗЗҮТЗГ		1-р улирал	Дотоод журмын дагуу статистик тайланг боловсруулж байгууллагын цахим хуудас, тогтмол гаргадаг тайлан товхимол, ном сэтгүүлд мэдээлсэн байна. %, Тайланд хамрагдсан үйлчилгээ эрхлэгч - 90%/86%
71		1-4-2.5	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2025 оны хагас жилийн статистик мэдээ, тайлан авч, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэх	ЗЗҮТЗГ		3-р улирал	Дотоод журмын дагуу статистик тайланг боловсруулж байгууллагын цахим хуудас, тогтмол гаргадаг тайлан товхимол, ном сэтгүүлд мэдээлсэн байна. %, Тайланд хамрагдсан үйлчилгээ эрхлэгч - 90%/86%
72		1-4-2.6	2024 оны статистик мэдээллийн эмхэтгэл боловсруулах, мэдээлэх	ЗЗҮТЗГ	ЗУХАГ	4-р улирал	2023 оны статистикийн мэдээллийн эмхэтгэл боловсруулж, байгууллагын цахим хуудсаар мэдээлсэн байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



А.ЛУВСАН-ОЧИР

Хуудас 10 нийт 43

ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
73		1-4-2.7	Харилцаа холбооны салбарын статистик үзүүлэлтүүдийн мэдээллийг ОУЦХБ-д хүргүүлэх, гарын авлагыг шинэчлэх	ЗЗҮТЗГ		жилдээ	Холбогдох үзүүлэлтийг хуваарийн дагуу ОУЦХБ-д хүргүүлсэн байна. ОУЦХБ-ын Статистик мэдээлэл цуглуулах гарын авлагыг шинэчилж, байгууллагын цахим хуудсанд мэдээлсэн байна.
74		1-4-2.8	Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчлэгчийн статистик тайлангийн үзүүлэлт, зааврыг шинэчлэн батлах	ЗЗҮТЗГ		1-2-р улирал	Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээ, Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ, Харилцаа холбооны сүлжээ дэд бүтцийн угсралт суурилуулалт, Мэдээллийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчдийн статистик мэдээ, тайлангийн үзүүлэлт, зааврыг шинэчлэн баталсан байна.
75		1-4-2.9	Цахимжуулсан тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээний хувийн хэргийг баяжуулах, ашиглах процесс, журмыг тодорхойлж, хувийн хэргийг үйлчилгээ эрхлэгч тус бүрээр системд оруулах	ЗУХАГ	Бүх газар	Жилдээ	Тусгай зөвшөөрөл, бүртгэлийн гэрчилгээний хувийн хэргийг баяжуулах, ашиглах процесс, журмыг тодорхойлсон, үйлчилгээ эрхлэгч тус бүрээр системд оруулсан байна.
76		1-4-2.10	Статистик тайлан мэдээний statistic.crc.gov.mn системд нэмэлт хөгжүүлэлт хийх	ЗЗҮТЗГ		1-2-р улирал	Статистик тайлан мэдээний statistic.crc.gov.mn системд хавсралт тайлан гаргах байдлыг хялбаршуулах, сонгох боломж нэмэх, удирдлагын модулийг боловсронгуй болгох зэрэг нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна.
77		1-4-3.1	Гар утасны өгөгдлийг бодлого боловсруулалтад ашиглах боломжийг судлах	ЗГ	ЗЗҮТЗГ	1-3-р улирал	Үндэсний статистикийн хороо, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран гар утасны өгөгдөл ашиглалтыг турших боломжийг судалж танилцуулсан байна.
78		1-4-3.2	Standard.crc.gov.mn нэгдсэн системийг стандартын боловсруулалтын үйл ажиллагаанд ашиглах	ЗГ		Жилдээ	standard.crc.gov.mn нэгдсэн системийг Стандартын техникийн хорооны үйл ажиллагаанд ашигласан байна. #, системд оруулсан стандартын төслийн тоо
79		1-4-3.3	Судалгааны байгууллагуудтай байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх	ЗГ		Жилдээ	МУИС-ийн МТЭС, ШУТИС-ийн МХТС-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтарсан 3 судалгаа хийж, 2 арга хэмжээ зохион байгуулсан байна.
80		1-4-3.4	"Харилцаа холбооны зохицуулалт - 2025" зөвлөгөөн зохион байгуулах	ЗГ	ЗУХАГ	4-р улирал	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 60-аас доошгүй төлөөллийг оролцуулсан нэг удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.



ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
81	Оролцогч талууд (Үйлчилгээ эрхлэгч, олон нийт, бусад)-тай нээлттэй, давтамжтай, үр ашигтай харилцаа бий болгох хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх	1-4-3.5	"Шуудангийн салбарын зохицуулалт - 2025" зөвлөгөөн зохион байгуулах	ШЗГ		4-р улирал	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчид болон холбогдох төрийн байгууллагуудын оролцоог хангаж, зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.
82		1-4-3.6	Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдэд өргөн нэвтрүүлгийн хөгжлийн чиг хандлага, техник технологийн дэвшлийн талаар "Өргөн нэвтрүүлгийн хөгжил - 2025" форум зохион байгуулах	ӨНЗГ	ЗУХАГ	2-р улирал	Форум арга хэмжээ зохион байгуулсан, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч холбогдох байгууллагуудын оролцоог хангасан байна.
83		1-4-3.7	Азийн өргөн нэвтрүүлгийн холбоотой үр ашигтай харилцаа бий болгох, хамтын ажиллагааг хөгжүүлэх	ӨНЗГ	ЗУХАГ	3-4-р улирал	Монгол Улсад зохион байгуулагдах Азийн өргөн нэвтрүүлгийн холбооны чуулга уулзалтад хамтран ажиллаж, хамтын ажиллагааг хөгжүүлсэн байна.
84		1-4-3.8	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын өдөрлөг "Экспо-2025" арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах	ЗУХАГ	Ажлын хэсэг	Жилдээ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын өдөрлөг "Экспо-2025" арга хэмжээ зохион байгуулахад байгууллагын оролцоог хангаж ажиллана.
85		1-4-3.9	Хөрш орнуудтай хил орчимд ашиглах радио давтамжийн зохицуулалтын санал боловсруулах, гэрээний төслийг бэлтгэх.	РДЗХГ		жилдээ	БНХАУ тай 2024 онд зохион байгуулсан уулзалт, хэлэлцээрийн дагуу дараагийн уулзалтаар хэлэлцэх радио давтамжийн зурвасын зохицуулалтын талаар судалгаа, туршилт хийх, БНХАУ-тай тохиролцсон байна.
86		1-4-3.10	Хувийн болон дотоод хэрэглээний харилцаанд зориулан радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглахдаа зөвшөөрөл авч ашиглах тухай зөвлөмжийг олон нийтэд хүргэх, хууль бус хэрэглээг багасгах	РДЗХГ		1-2-р улирал	Уул уурхай, газар тариалан, харуул хамгаалалт, барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдэд Радио долгионы тухай хуулийн талаар мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн байна.
87		1-4-3.11	Баталгаажуулалтын үйл ажиллагааг сурталчлан таниулах талаар Гаалийн ерөнхий газартай хамтын ажиллагааг хөгжүүлэх	РДЗХГ	ШЗГ	Жилдээ	Хилээр нэвтэрч буй харилцаа холбооны тоног төхөөрөмжийг баталгаажсан эсэхэд хяналт тавихаар Гаалийн ерөнхий газартай хамтын ажиллагааг өргөжүүлж, гүний гаалийн мэргэжлийн байцаагч нарт сургалт зохион байгуулсан байна.
88		1-4-3.12	Дэлхийн Шуудан холбооны 28-р их хуралд Монгол улсын байр суурийг танилцуулах, саналыг Дэлхийн шуудан холбооны конвенцид тусгахад хамтарч ажиллах	ШЗГ		3-р улирал	Дэлхийн шуудан холбооны конвенцид оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг боловсруулахад ЦХИХХЯ-д дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах ба үр дүнг ДЗХ, ХХЗХ-ны хуралдаанд танилцуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



А.ЛУВСАН-ОЧИР

Хуудас 12 нийт 43

ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
89		1-4-3.13	Кибер халдлага, зөрчлийн талаар мэдээлэл түгээх, шинжилгээ хийх чиглэлээр үйлчилгээ эрхлэгчдийн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	ЗГ		2-р улирал	Олон улсад нийтлэг хэрэгждэг "Халдлага, зөрчлийн мэдээлэл түгээх, шинжилгээ хийх төв" (ISAC)-ийн талаар холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дунд семинар зохион байгуулсан байна.
90		1-4-3.14	Ази номхон далайн шуудангийн холбоо (ARPU)-ны гүйцэтгэх зөвлөлийн хурлыг /Executive Committee Meeting/ Монгол улсад зохион байгуулахад оролцоог ханган, хамтарч ажиллах	ШЗГ		3-р улирал	Ази Номхон Далайн Шуудангийн Холбооны гүйцэтгэх зөвлөлийн хуралд байгууллагын оролцоог ханган хамтарч ажилласан байна.
91		1-4-4.1	"Харилцаа холбооны хөгжил - 2025" бүсийн зөвлөгөөн зохион байгуулах	ЗУХАГ	Бүх газар	Жилдээ	Баруун бүсэд зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.
92		1-4-4.2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд харилцаа холбооны салбарын статистик тайлан мэдээ гаргах аргагүйгээр хангах	ЗЗҮТЗГ		Жилдээ	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд чиглэл бүрээр статистик тайлан мэдээ гаргах сургалтууд зохион байгуулсан байна.
93		1-4-4.3	2025 онд шинээр батлах статистик тайлангийн маягт, зааврыг эмхэтгэн гарын авлага хийж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг мэдээллээр хангах	ЗЗҮТЗГ	ЗУХАГ	2-3-р улирал	Гарын авлагыг хэвлүүлж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг мэдээллээр хангасан байна.
94		1-4-4.4	"Дэлхийн радиогийн өдөр"-ийн хүрээнд олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажил хийх	ӨНЗГ		1-р улирал	Олон нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны ажил (постер 3-4) хийсэн байна.
95		1-4-4.5	"Дэлхийн телевизийн өдөр"-ийн хүрээнд олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажил хийх	ӨНЗГ		4-р улирал	Олон нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны ажил (постер 1-2) хийсэн байна.
96		1-4-4.6	Дэлхийн шуудангийн өдрийн хүрээнд олон нийтэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулах	ШЗГ		4-р улирал	Олон нийтэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны ажил (постер, нийтлэл) хийсэн байна.
97	Оролцогч талууд (Үйлчилгээ эрхлэгч, олон нийт, бусад)-тай нээлттэй, давтамжтай, үр ашигтай харилцаа бий болгох хүрээнд үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	1-4-4.7	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн цахим сургалтын системийг нэвтрүүлэх	ШЗГ		1-р улирал	Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, технологи ажиллагааны цуврал видео хичээлүүдийг цахим сургалтын системд байршуулан, улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн хилийн чанад дахь хамтрагч байгууллагуудын сургалтын ирц, оролцоог нэмэгдүүлсэн байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



А.ЛУВСАН-ОЧИР

Хуудас 13 нийт 43

ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
98		1-4-4.8	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн ажилтнуудыг чадавхжуулах, мэргэшил олгох сургалтыг Шинжлэн ухаан технологийн их сургуулийн Мэдээлэл, холбооны технологийн сургуультай хамтран зохион байгуулах	ШЗГ		2-р улирал	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн ажилтнуудад сертификат олгох сургалт зохион байгуулсан байна. # сургалтад хамрагдсан ажилтны тоо
99		1-4-4.9	Шуудангийн үйлчилгээ эрхлэгчдэд шуудангийн салбарын хууль эрх зүй, стандарт, технологи ажиллагаа, цаг үеийн мэдээллээр хангах	ШЗГ		Сар бүр	Шуудангийн салбарын хууль эрх зүй, цаг үеийн мэдээлэл бүхий цахим сонинг сар бүр гарган, шуудангийн үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлсэн байна.
100		1-4-4.10	Цахилгаан соронзон орны талаарх зөвлөмж, мэдээллийг олон нийтэд хүргэх, таниулах арга хэмжээ авах	РДЗХГ	ЗУХАГ	жилдээ	Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчидтэй хамтарч цахилгаан соронзон орны нөлөөллийн талаарх судалгааны үр дүн, зөвлөмж, мэдээллийг олон нийтэд хүргэж, таниулах ажлыг зохион байгуулсан, байгууллагын цахим хуудсан дахь мэдээллийг баяжуулж, шинэчилсэн байна.
101	Гомдол, маргаан шийдвэрлэх үйл ажиллагааг хялбаршуулах, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх	1-4-5.1	Хэрэглэгчээс ирүүлж буй гомдлын агуулгад дүн шинжилгээ хийж, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх, хэрэглэгчид мэдээлэл, зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулах	ЗУХАГ	Бүх газар	Жилдээ	Хэрэглэгчийн гомдол ихээр гарч буй харилцаа холбооны үйлчилгээний талаар зөвлөмж, мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэсэн байна.
102		1-4-5.2	Хэрэглэгчийн гомдлын дагуу интернэтийн үйлчилгээ эрхлэгчдийн үйлчилгээний чанарт хяналт тавих	ЗГ		Жилдээ	Хэрэглэгчийн гомдол гарах үед интернэтийн чанарын мониторингийн системийг (speedtest.mn) ашиглан хэмжилт хийж, холбогдох арга хэмжээ авах ба хэмжилтийн жилийн тайланг нэгтгэн, танилцуулсан байна.
1.5. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 5. САНХҮҮГИЙН ЗОХИСТ ХАРЬЦААГ ХАНГАХ, ҮР АШИГТАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ							
103	Зохицуулалтын үйлчилгээний хөлс, хязгаарлагдмал нөөцийн ашиглалт, үйлчилгээний төлбөрийг cost-cover зарчмаар шинэчлэн тогтоох	1-5-1.2	Дугаарлалтын зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулах санал боловсруулах	ЗЗҮТЗГ	ЗГ	Жилдээ	Дугаарлалтын зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулах санал боловсруулж ДЗХ-д танилцуулсан байна.
104	Авлага үүсэхээс сэргийлэх тогтолцоо бүрдүүлэх	1-5-2.1	Тусгай зөвшөөрлийн төлбөрийн нэхэмжлэл, авлага бүртгэлд хөндлөнгийн аудитын байгууллагаар шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах	ЗУХАГ		1-2-р улирал	Тусгай зөвшөөрөлтэй холбоотой авлагын бүртгэлийн ажиллагаанд хөндлөнгийн аудитын шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна.

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА



А.ЛУВСАН-ОЧИР

Хуудас 14 нийт 43

ДД	Зорилго, эрх хэмжээ, чиг үүрэг	Дугаар	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтрах нэгж	Гүйцэтгэх хугацаа	Гарц
105	Зардал үр ашигтай зохицуулалтад чиглэсэн байдлыг хангах	1-5-3.1	2024 оны санхүүгийн тайланд зохистой харьцааны шинжилгээ хийх	ЗУХАГ	ЗЗҮТЗГ	2-р улирал	Санхүүгийн зохист харьцааг 2024 оны санхүүгийн орлого, зардлын шинжилгээ болон олон улсад мөрдөгддөг нийтлэг стандартад нийцүүлэн тодорхойлж, ДЗХ-д танилцуулсан байна.
106		1-5-3.2	Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн орлого, зардлын шинжилгээ хийх	ЗУХАГ	ЗЗҮТЗГ	4-р улирал	Байгууллагын санхүүгийн орлого, зардлын зохистой харьцааны шинжилгээ хийж, ДЗХ, Хорооны хуралдаанд танилцуулсан байна.
107		1-5-3.3	Байгууллагын 2026 оны санхүүгийн орлого, зардлын төлөвлөгөө боловсруулах	ЗУХАГ	ЗЗҮТЗГ	4-р улирал	Байгууллагын 2026 оны орлого, зардлын төлөвлөгөөг боловсруулж, ДЗХ-д танилцуулж, Хорооны хуралдаанаар батлуулсан байна.
108		1-5-3.4	Зохицуулалтын үйл ажиллагааны зардлын бүтцэд дүн шинжилгээ хийх	ЗЗҮТЗГ	ЗУХАГ	2-3-р улирал	Зардлын дүн шинжилгээнд үндэслэн Хорооны орлогын эх үүсвэрт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, санал дүгнэлтийг танилцуулсан байна.
1.6. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 6. БАЙГУУЛЛАГА ҮНЭ ЦЭНЭТЭЙ КАПИТАЛАА НЭМЭГДҮҮЛЭХ ЗАМААР ЧАДАМЖАА БАЙНГА ДЭЭШЛҮҮЛЖ, БҮТЭЭМЖ ДЭМЖСЭН СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА БОЛОХ							
109	Байгууллагын хараат бус статусыг бэхжүүлэх, захиргаа удирдлагын тогтолцоог орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх	1-6-1.1	Байгууллагын бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр Зохицуулах байгууллагын олон улсын мэргэжлийн холбоодтой бодлогын зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, зөвлөгөө авах	ЗУХАГ		Жилдээ	Зохицуулах байгууллагын хараат бус, бие даасан байдлын талаар ОУЦХБ (ITU), Дэлхийн худалдааны байгууллага (WTO) зэрэг олон улсын байгууллагуудтай мэдээлэл солилцох, зөвлөгөө, туслалцаа авах, уулзалт зохион байгуулах зэргээр хамтын ажиллагааг үргэлжлүүлж, шаардлагатай тохиолдолд зөвлөх урьж сургалт зохион байгуулах эсхүл тухайн байгууллагууд дээр очиж ажилласан байна.
110		1-6-1.2	Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах	Ажлын албаны дарга	ХХНБД Ажлын хэсэг	Жилдээ	Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.
111		1-6-2.1	Харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээ, тухайн үйлчилгээний үнэ тариф, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ хүрээгүй хүн ам, газар нутаг (дүүрэг, хороо, сум, баг) зэргийг тандан судалж, суурь судалгааны баазыг бий болгох, тогтмолжуулах	ЗЗҮТЗГ	ЗГ	2-3-р улирал	Харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээ, тухайн үйлчилгээний үнэ тариф харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ хүрээгүй хүн ам, газар нутаг (дүүрэг, хороо, сум, баг) зэргийг тандан судалж суурь судалгааны баазыг бий болгосон байна.

